



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
АЛБАН ДААЛГАВАР

2020 оны 12 сарын 21 өдөр

Дугаар 29

Улаанбаатар хот

Зорилтот бүлгийн иргэдийг коронавируст  
халдвар (КОВИД-19)-ын болзошгүй эрсдэлээс  
урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг  
хангах тухай

Манай улсад коронавируст халдвар (КОВИД-19)-ын дотоодын тохиолдол бүртгэгдэж, Улаанбаатар хот, Сэлэнгэ, Дархан-Уул, Говьсүмбэр, Орхон, Дорноговь, Архангай аймгуудад халдвар голомтлон гарч өвчлөл орон нутагруу чиглэж байна. Ард иргэдэд эрсдэл тулгарч байна.

Нэгдсэн үндэстний байгууллага, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас зорилтот бүлгийн иргэд буюу өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүнд, хэвтрийн өвчтөн, эх, хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээнд онцгой анхаарч, өвөрмөц хариу арга хэмжээг төлөвлөн, хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

Иймд, зорилтот бүлгийн иргэдэд чиглэсэн Коронавируст халдвар (КОВИД-19)-ын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эмнэлгийн тусламж, үйлчилгээний бэлэн байдал, хариу арга хэмжээг эрчимжүүлэх зорилгоор ДААЛГАХ нь:

НЭГ. ТООН МЭДЭЭГ НАСНЫ БҮТЭЦ, ХАВСАРСАН ӨВЧИН ЭМГЭГ, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН БАЙДЛААР ГАРГАЖ, МЭДЭЭЛЭХ:

1.1 Коронавируст халдвар (КОВИД-19)-аар өвчилсөн иргэдийн тоон мэдээнд дараах жишиг үзүүлэлтийг тусган боловсруулж, тусгаарлан ажиглах байр, тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудад хүргүүлэн, хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт.

1.2 Зорилтот бүлгийн иргэдийн тоон мэдээний төрөлд тусгах жишиг үзүүлэлт:

1.2.1 Ахмад: эмэгтэй 55, эрэгтэй 60-аас дээш настай,

1.2.2 Архаг суурь өвчтэй иргэд:

- a. Артерийн даралт ихсэх
- b. Диабет
- c. Хавдар
- d. Дархлаа дарангуйлах эмчилгээтэй
- e. Эрхтэн шилжүүлэх хагалгаанд орсон

1.2.3 5 хүртэлх насны хүүхэд,

1.2.4 Жирэмсэн эх,

1.2.5 Хөгжлийн бэрхшээлтэй хүн



## ХОЁР. ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТ, ХЭРЭГЖИЛТИЙГ САЙЖРУУЛАХ ХҮРЭЭНД:

### 2.1 Зорилтот бүлгийн бүртгэл, мэдээлэл, хяналт:

- 2.1.1 Нутаг дэвсгэр, үйлчлэх хүрээний хүн амын доторх зорилтот бүлгийн иргэдийн үйл ажиллагаанд хяналт тавьж, хариуцаж ажиллах багийг томилгоожуулж, тогтмол мэдээлэл авч, дүгнэлт хийж ажиллах,
- 2.1.2 Сум, хороо, аймаг, дүүргийн зорилтот бүлгийн хүн амын нарийвчилсан судалгааг гаргах /өрхөөр, насаар, өвчний төрлөөр, гэрийн хаягаар/,
- 2.1.3 Зорилтот бүлгийн хүн амын хөдөлгөөнийг хязгаарлах, Үүнд:
  - Олон нийтийн газраар явахад хязгаарлалт хийх /автобус, дэлгүүр, банк, хоолны газар, олон хүн цугларах хурал, уулзалт, нийтийн бүжиг, хэсэг бүлгээр нийлж тоглох гэх мэт/
  - Тухайн бүлгүүдийн халдварын сэргийлэлт, хяналтад хороо, багийн дарга, нийгмийн ажилтанаар хяналт хийлгэх,
  - ӨЭМТ, СЭМТ-тэй хамтран тэдэнд чиглэсэн эрүүл мэндийн зөвлөгөө, сэргийлэх, нөлөөллийн ажлыг эрчимжүүлэх,
- 2.1.4 Зорилтот бүлэгт чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны цуврал зөвлөмж, сэрэмжлүүлэг боловсруулан олон нийтийн мэдээллийн хэрэгслээр тогтмол хүргэхийг Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Онцгой Комисс, Шуурхай Штабын дарга нарт.

### 2.2 ӨЭМТ, СЭМТ - ийн түвшинд:

- 2.2.1 Зорилтот бүлгийн нарийвчилсан судалгаанд тулгуурлан хариу арга хэмжээний төлөвлөгөө гарган ажиллах, цахим, болон зайнаас зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлэх,
- 2.2.2 Гэрийн эргэлт, өдрийн эмчилгээг тухайн зорилтот бүлгийн хүн амд үзүүлэх /хуваар гарган ажиллах/,
- 2.2.3 КОВИД-19 илрүүлэх шинжилгээнд хамруулах,
- 2.2.4 Зорилтот бүлэг, тэдний гэр бүлийнхэнд халдвараас урьдчилсан сэргийлэх, дасгал хөдөлгөөн хийх, маск зүүх, зай барих, гараа халдваргүйтгэх, илчлэг сайтай, чанартай, хоол хүнс хэрэглэх, гэр, сууцны агаарын чанар, эрүүл ахуйг сайжруулах зөвлөмж хүргэх,
- 2.2.5 Шаардлагагүй үед эмнэлгээр үйлчлүүлэхээс зайлсхийх сэрэмжлүүлэг хүргүүлэх,
- 2.2.6 Алслагдсан сум, баг, байгаль цаг уурын хүнд нөхцөлд амьдарч байгаа болон зорилтот бүлгийн эх, хүүхдэд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээнд онцгой анхаарах;
- 2.2.7 Нярай болон хүүхдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чиглэлээр батлагдсан стандарт, тушаал, журам, заавар, халдвар хамгааллын дүрмийг чанд мөрдөж ажиллах;
- 2.2.8 Томуу, томуу төст өвчний үед 5 хүртэлх насны хүүхдэд өрх, сумын эрүүл мэндийн төвөөр дамжуулан олгох эм, витаминжуулалт, түүний зарцуулалтад хяналт тавих үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах;
- 2.2.9 Бага насны хүүхдийн дунд улирлын чанартай амьсгалын замын болон бусад халдварт өвчний дэгдэлтээс урьдчилан сэргийлж, эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийг бүрдүүлэн, түргэн тусламжийн үйлчилгээ, эмнэлгийн орны зохицуулалтын бэлэн байдалд хяналт тавьж ажиллах.

### 2.3 Нэгдсэн эмнэлэг, лавлагаа шатлалын түвшинд:


- 2.3.1 Зорилтот бүлэгт тусламж, үйлчилгээ үзүүлэх хариу арга хэмжээний 3-4 багийг сургаж, бэлэн байдлыг хангуулах,



- 2.3.2 Зорилтот бүлэгт үзүүлэх өвөрмөц эмнэлзүй, зөвлөгөө, хамлдварын сэргийлэлт, хяналтын сургалтыг тогтмол хийж, тусламж, үйлчилгээ үзүүлэгчдийг мэргэжил арга зүйн дэмжлэгээр хангах,
- 2.3.3 Зорилтот бүлгийн хүн амыг шаардлагагүй эмнэлэгт хэвтүүлэхээс зайлсхийх,
- 2.3.4 Эмнэлэгт хэвтүүлэн эмчлэх үед халдварын сэргийлэлт, хяналтын дэглэмийн зураглалыг гаргаж, баримтлах,
- 2.3.5 Эмнэлгээр үйлчлүүлж буй зорилтот бүлгийн иргэн шинж тэмдэггүй тохиолдолд заавал ковид-19 илрүүлэх ТТ, сэжигтэй тохиолдол бүрт ПГУ шинжилгээ хийх,
- 2.3.6 Суурь болон архаг өвчтэй иргэдэд тухайн өвчний чиглэлийн тусламжийг хүртээмжтэй, чанартай хүргэх.

#### ГУРАВ. ХЯНАЛТ. ҮНЭЛГЭЭ.

- 3.1 Коронавируст халдвар /КОВИД-19/-ын болон өдөр тутмын эмнэлгийн тусламж, үйлчилгээнд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх, тэдгээрийн зохистой хэрэглээ, зарцуулалтад хяналт тавих, нөөцийн мэдээллийг /www.burtgel.mohs.mn/ цахим програмд тухай бүр, бодитоор мэдээлэх
- 3.2 Коронавируст халдвар /КОВИД-19/-ын үед хэрэглэх эмийн аюулгүй байдал, үр дүнгийн талаарх мэдээллийг цаг тухайд нь зохих журмын дагуу шуурхай мэдээлэх,
- 3.3 Албан даалгаварын тайланг байгууллагаас тогтмол ирүүлж байгаа мэдээнд тусган, тулгамдсан асуудлыг тухайн байгууллагын болон Эрүүл мэндийн яамны тохиолдлын удирдлагын тогтолцооны багийн хуралд ирүүлж, хэлэлцүүлж шийдвэрлүүлж байна.

САЙД  Т.МӨНХСАЙХАН